ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/18/НА-СТА-ТТЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер Б.Долгорсүрэн<br>Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn<br>Ахлах аудитор С.Отгонхорлоо<br>Утас: 261628 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn<br>Аудитор С.Шийлэгмаа<br>Утас: 261628 Цахим хаяг: shiilegmaas@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ....3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ....13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ....13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ....13
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт ....14
3.5.2 Авлага ....17
3.5.3 Урьдчилгаа ....18
3.5.4 Бараа материал ....18
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө ....19
3.5.6 Үндсэн хөрөнгө ....20
3.5.7 Өр төлбөр ....21
3.5.8 Засгийн газрын хувь оролцоо ....21
4. АУДИТЫН ТАЙЛАН ....27
4.1 Ерөнхий зүйл ....27
4.2 Материаллаг байдал ....27
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ....27
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....27
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....27
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ....30
5.1 Албан шаардлага ....30
5.2 Зөвлөмж ....30
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ....32

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ДЦШ | Дотоодын цэргийн штаб |
| НХЖХОНАБХА | Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТӨҮГ | Төрийн өмчит үйлдвэрийн газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 791

танай ____________-ны №____________-т

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ДОТООДЫН ЦЭРГИЙН
КОМАНДЛАГЧ, ХОШУУЧ ГЕНЕРАЛ
Ж.БОЛД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газар, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан А/71, А/175 дугаар тушаал, Цагдаагийн ерөнхий газрын даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2025 оны А/177 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Процессын дахин инженерчлэл”-ийн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэхэд нийт 305.8 сая төгрөг зарцуулсан байна.

## Аудитын гол асуудал

Цагдаагийн ерөнхий газрын даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2025 оны А/73 дугаар тушаалаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг дэмжих ажиллагаанд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын баг оролцуулахтай холбогдуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 25,442.4 сая төгрөгийн төсөв батласнаас 25,376.5 сая төгрөгийн гэрээ байгуулж, 20,443.8 сая төгрөгийн гүйцэтгэлээр олгож, 4,926.0 төгрөгийн гэрээг цуцалж, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тайлант оны урсгал төсвөөс 344 нэр төрлийн 784.9 сая төгрөгийн бараа, материал худалдан авахаар шийдвэрлэж, 82 нэр төрлийн 468.0 сая төгрөгийн 4 гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 521 алба хаагчид 41,724.5 сая төгрөгийн тэтгэмж олгож, “Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “Цэргийн алба хаагчийн нэг удаагийн тэтгэмжийн 18 сар хүртэлх хугацаанд ногдох хэсгийг цэргийн алба хаасны тэтгэвэр авах эрх үүссэнээс хойш үргэлжлүүлэн алба хааж байгаа офицер, ахлагчид цэргийн албанаас чөлөөлөгдөхөөс өмнө урьдчилан олгож болно” гэж заасны дагуу 13 албан хаагчид 739.3 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгож, аймгийн төвөөс алслагдсан суманд тасралтгүй 5 жил ажилласан 220 алба хаагчид 6,622.4 сая төгрөгийн мөнгөн урамшил олгосон байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

С.МАГНАЙСҮРЭН

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 138,788,232.3 | 185,067,280.2 |
| 2 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 15,912,362.1 | 16,114,696.4 |
| 3 | АВЛАГА | 1,251,284.3 | 8,344,879.9 |
| 4 | УРЬДЧИЛГАА | 21,527,802.1 | 12,057,210.8 |
| 5 | БАРАА МАТЕРИАЛ | 84,917,700.1 | 123,189,452.7 |
| 6 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 15,179,083.7 | 25,361,040.4 |
| 7 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 304,019,209.0 | 336,679,739.6 |
| 8 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 304,019,209.0 | 336,679,739.6 |
| 9 | Биет хөрөнгө | 279,161,924.3 | 311,663,964.0 |
| 10 | Биет бус хөрөнгө | 24,857,284.7 | 25,015,775.6 |
| 11 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 442,807,441.3 | 521,747,019.8 |
| 12 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 12,769,736.2 | 17,545,219.4 |
| 13 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 12,769,736.2 | 17,545,219.4 |
| 14 | Өглөг | 1,902,763.4 | 3,676,175.5 |
| 15 | Урьдчилж орсон орлого | 10,866,972.8 | 13,869,044.0 |
| 16 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 430,037,705.0 | 504,201,800.4 |
| 17 | Засгийн газрын хувь оролцоо | 430,037,705.0 | 504,201,800.4 |
| 18 | Засгийн газрын оруулсан капитал | 88,118,325.3 | 88,108,188.4 |
| 19 | Хуримтлагдсан үр дүн | 287,395,989.9 | 362,877,139.1 |
| 20 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 54,523,389.9 | 53,216,472.9 |
| 21 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 442,807,441.3 | 521,747,019.8 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 623,172,201.2 | 748,000,481.6 |
| 2 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 65,720,511.4 | 748,000,481.6 |
| 3 | Тусламжийн орлого | 789,140.9 | 692,321,143.8 |
| 4 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 557,451,689.8 | - |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 539,639,771.5 | 672,044,055.1 |
| 6 | УРСГАЛ ЗАРДАЛ | 539,639,771.5 | 672,044,055.1 |
| 7 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 484,450,876.6 | 603,522,243.1 |
| 8 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 357,338,228.7 | 427,985,246.6 |
| 9 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 8,429,607.4 | 10,514,914.1 |
| 10 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,750,660.3 | 9,697,579.6 |
| 11 | Хангамж, бараа материалын зардал | 18,133,739.9 | 18,433,779.3 |
| 12 | Нормативд зардал | 22,272,856.7 | 35,759,674.0 |
| 13 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,304,383.6 | 4,603,628.1 |
| 14 | Томилолт, зочны зардал | 1,756,969.1 | 1,658,528.4 |
| 15 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 26,558,969.5 | 45,521,987.6 |
| 16 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,905,461.6 | 49,346,905.5 |
| 17 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 55,188,894.9 | 68,521,812.0 |
| 18 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 83,532,429.7 | 75,956,426.5 |
| 19 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 1,026.0 | 282,162.8 |
| 20 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 2,102,761.7 | 2,208,775.9 |
| 21 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | (2,101,735.7) | (1,926,613.1) |
| 22 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 81,430,694.1 | 74,029,813.4 |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 363,841,458.2 | - | 363,841,458.2 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (16,149,628.5) | - | (16,149,628.5) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 347,691,829.7 | - | 347,691,829.7 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (690,521.9) | - | (690,521.9) |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 1,605,703.2 | - | 1,605,703.2 |
| 6 | Тайлант үеийн үр дүн | 81,430,694.1 | - | 81,430,694.1 |
| 7 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 430,037,705.0 | - | 430,037,705.0 |
| 8 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 430,037,705.0 | - | 430,037,705.0 |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 2,687,090.3 | - | 2,687,090.3 |
| 10 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 432,724,795.4 | - | 432,724,795.4 |
| 11 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (1,306,804.9) | - | (1,306,804.9) |
| 12 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | (7,603.8) | - | (7,603.8) |
| 13 | Өмчид гарсан өөрчлөлт | 1,238,399.6 | - | (1,238,399.6) |
| 14 | Тайлант үеийн үр дүн | 74,029,813.4 | - | 74,029,813.4 |
| 15 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 504,201,800.4 | - | 504,201,800.4 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 581,834,900.2 | 718,704,386.3 |
| 2 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 23,887,147.8 | 718,704,386.3 |
| 3 | Нийтлэг татварын бус орлого | 23,887,147.8 | 26,378,121.7 |
| 4 | Тусламжийн орлого | | 692,326,264.7 |
| 5 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 557,947,752.4 | |
| 6 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 545,874,750.0 | 665,216,577.1 |
| 7 | УРСГАЛ ЗАРДАЛ | 545,874,750.0 | 665,216,577.1 |
| 8 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 488,889,951.9 | 592,265,139.1 |
| 9 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 358,659,580.3 | 431,358,614.7 |
| 10 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 8,576,603.1 | 10,555,756.6 |
| 11 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,912,810.7 | 9,777,573.0 |
| 12 | Хангамж, бараа материалын зардал | 14,337,947.2 | 16,377,756.7 |
| 13 | Нормативт зардал | 34,246,134.0 | 44,352,093.8 |
| 14 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,020,490.5 | 17,772,103.4 |
| 15 | Томилолт, зочны зардал | 1,806,844.9 | 1,686,453.2 |
| 16 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 48,350,264.5 | 53,661,236.1 |
| 17 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,979,276.8 | 6,723,551.5 |
| 18 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 56,984,798.1 | 72,951,438.0 |
| 19 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 35,960,150.2 | 53,487,809.2 |
| 20 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 35,239,247.9 | 54,438,452.8 |
| 21 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 35,239,247.9 | 54,438,452.8 |
| 22 | Дотоод эх үүсвэрээр | 35,239,247.9 | 54,438,452.8 |
| 23 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (35,239,247.9) | (54,438,452.8) |
| 24 | Бусад эх үүсвэр | | 1,152,977.9 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 396,126.8 | |
| 26 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | (396,126.8) | 1,152,977.9 |
| 27 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 324,775.5 | 202,334.3 |
| 28 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 15,587,586.6 | 15,912,362.1 |
| 29 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 15,912,362.1 | 16,114,696.4 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/төгрөгөөр/

| Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 655,355,676,200.00 | 642,611,955,949.03 | 12,743,720,250.97 | 98.1 |
| Татварын бус орлого | 655,355,676,200.00 | 642,611,955,949.03 | 12,743,720,250.97 | 98.1 |
| Нийтлэг татварын бус орлого | 16,750,128,000.00 | 20,124,679,005.26 | (3,374,551,005.26) | 120.1 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 16,750,128,000.00 | 20,124,679,005.26 | (3,374,551,005.26) | 120.1 |
| Тусламжийн орлого | 638,605,548,200.00 | 622,487,276,943.77 | 16,118,271,256.23 | 97.5 |
| Хандив тусламж /дотоод/ | 252,495,000.00 | 358,020,000.00 | (105,525,000.00) | 141.8 |
| Төсвөөс санхүүжих | 638,353,053,200.00 | 622,129,256,943.77 | 16,223,796,256.23 | 97.5 |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 655,355,676,200.00 | 638,552,697,621.38 | 16,802,978,578.62 | 97.4 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 615,602,376,200.00 | 604,265,754,975.06 | 11,336,621,224.94 | 98.2 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 564,363,926,400.00 | 554,577,233,205.01 | 9,786,693,194.99 | 98.3 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 414,375,947,000.00 | 411,054,595,443.69 | 3,321,351,556.31 | 99.2 |
| Үндсэн цалин | 210,554,152,000.00 | 218,967,242,137.60 | (8,413,090,137.60) | 104.0 |
| Нэмэгдэл | 159,161,788,500.00 | 151,492,408,851.03 | 7,669,379,648.97 | 95.2 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 18,360,079,900.00 | 15,759,393,902.95 | 2,600,685,997.05 | 85.8 |
| Урамшуулал | 17,140,944,600.00 | 16,579,464,557.50 | 561,480,042.50 | 96.7 |
| Гэрээт ажлын хөлс | 9,158,982,000.00 | 8,256,085,994.61 | 902,896,005.39 | 90.1 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 10,181,516,500.00 | 9,510,499,080.58 | 671,017,419.42 | 93.4 |
| Тэтгэврийн даатгал | 1,017,411,500.00 | 1,015,505,453.93 | 1,906,046.07 | 99.8 |
| Тэтгэмжийн даатгал | 119,685,200.00 | 118,238,582.91 | 1,446,617.09 | 98.8 |
| ҮОМШӨ-ний даатгал | 46,509,000.00 | 46,048,976.52 | 460,023.48 | 99.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 108,680,500.00 | 25,665,931.45 | 83,014,568.55 | 23.6 |
| Эрүүл мэндийн даатгал | 8,889,230,300.00 | 8,305,040,135.77 | 584,190,164.23 | 93.4 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 10,134,269,100.00 | 9,356,039,077.16 | 778,230,022.84 | 92.3 |
| Гэрэл, цахилгаан | 3,969,332,400.00 | 3,578,785,870.65 | 390,546,529.35 | 90.2 |
| Түлш, халаалт | 4,920,087,100.00 | 4,580,740,035.97 | 339,347,064.03 | 93.1 |
| Цэвэр, бохир ус | 827,118,800.00 | 717,926,315.54 | 109,192,484.46 | 86.8 |
| Байрны түрээс | 417,730,800.00 | 478,586,855.00 | (60,856,055.00) | 114.6 |
| Хангамж, бараа материалын зардал | 15,660,492,100.00 | 14,387,470,317.32 | 1,273,021,782.68 | 91.9 |
| Бичиг хэрэг | 2,260,210,200.00 | 1,837,908,454.23 | 422,301,745.77 | 81.3 |
| Тээвэр, шатахуун | 11,183,959,500.00 | 10,771,832,753.46 | 412,126,746.54 | 96.3 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 805,762,900.00 | 700,240,689.13 | 105,522,210.87 | 86.9 |
| Ном, хэвлэл | 30,279,200.00 | 26,607,100.00 | 3,672,100.00 | 87.9 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 72,884,100.00 | 48,724,300.00 | 24,159,800.00 | 66.9 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,307,396,200.00 | 1,002,157,020.50 | 305,239,179.50 | 76.7 |
| Нормативт зардал | 42,853,735,100.00 | 41,787,401,474.08 | 1,066,333,625.92 | 97.5 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 110,451,200.00 | 76,947,649.50 | 33,503,550.50 | 69.7 |
| Хоол, хүнс | 4,659,102,600.00 | 4,175,589,240.18 | 483,513,359.82 | 89.6 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 38,084,181,300.00 | 37,534,864,584.40 | 549,316,715.60 | 98.6 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 9,248,082,500.00 | 8,725,915,682.63 | 522,166,817.37 | 94.4 |
| Багаж, техник, хэрэгсэл | 4,260,059,200.00 | 4,177,766,505.40 | 82,292,694.60 | 98.1 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 206,271,200.00 | 131,881,513.00 | 74,389,687.00 | 63.9 |
| Урсгал засвар | 4,781,752,100.00 | 4,416,267,664.23 | 365,484,435.77 | 92.4 |
| Томилолт, зочны зардал | 1,971,169,800.00 | 1,418,492,912.20 | 552,676,887.80 | 72.0 |
| Гадаад албан томилолт | 85,688,300.00 | 97,328,637.20 | (11,640,337.20) | 113.6 |
| Дотоод албан томилолт | 1,885,481,500.00 | 1,321,164,275.00 | 564,317,225.00 | 70.1 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 54,950,615,500.00 | 54,017,249,254.35 | 933,366,245.65 | 98.3 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 50,764,068,400.00 | 50,216,681,475.97 | 547,386,924.03 | 98.9 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,548,800.00 | - | 4,548,800.00 | - |
| Даатгалын үйлчилгээ | 234,235,800.00 | 227,277,276.63 | 6,958,523.37 | 97.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 318,915,700.00 | 255,339,123.07 | 63,576,576.93 | 80.1 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 52,856,100.00 | 29,937,543.00 | 22,918,557.00 | 56.6 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,639,811,800.00 | 1,397,068,894.08 | 242,742,905.92 | 85.2 |
| Газрын төлбөр | 194,354,900.00 | 167,924,951.90 | 26,429,948.10 | 86.4 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,741,824,000.00 | 1,723,019,989.70 | 18,804,010.30 | 98.9 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4,988,098,800.00 | 4,319,569,963.00 | 668,528,837.00 | 86.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 370,836,900.00 | 360,193,409.00 | 10,643,491.00 | 97.1 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,617,261,900.00 | 3,959,376,554.00 | 657,885,346.00 | 85.8 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 51,238,449,800.00 | 49,688,521,770.05 | 1,549,928,029.95 | 97.0 |
| Засгийн газрын урсгал шилжүүлэг | 147,408,000.00 | 147,408,000.00 | - | 100.0 |
| Засгийн газрын гадаад шилжүүлэг | 147,408,000.00 | 147,408,000.00 | - | 100.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 51,091,041,800.00 | 49,541,113,770.05 | 1,549,928,029.95 | 97.0 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,827,731,500.00 | 1,822,507,010.00 | 5,224,490.00 | 99.7 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 40,066,099,100.00 | 39,142,437,927.91 | 923,661,172.09 | 97.7 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,944,767,200.00 | 7,571,669,895.14 | 373,097,304.86 | 95.3 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,252,444,000.00 | 1,004,498,937.00 | 247,945,063.00 | 80.2 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 39,753,300,000.00 | 34,286,942,646.32 | 5,466,357,353.68 | 86.2 |
| Барилга байгууламж | 8,468,200,000.00 | 8,119,758,749.00 | 348,441,251.00 | 95.9 |
| Их засвар | 1,671,500,000.00 | 1,671,408,107.00 | 91,893.00 | 100.0 |
| Тоног төхөөрөмж | 29,613,600,000.00 | 24,495,775,790.32 | 5,117,824,209.68 | 82.7 |
| ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | - | 4,059,258,327.65 | (4,059,258,327.65) | |
| АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | (4,059,258,327.65) | 4,059,258,327.65 | |
| Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | - | (4,059,258,327.65) | 4,059,258,327.65 | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 350,000.00 | (350,000.00) | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 350,000.00 | (350,000.00) | |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 11739 | 11739 | - | 100.0 |
| Удирдах ажилтан | 169 | 169 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 10364 | 10364 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 494 | 494 | - | 100.0 |
| Гэрээт ажилтан | 712 | 712 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт/Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 63,770,843,705.49 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 59,164,956,020.49 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 56,395,452,120.49 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 20,290,764,796.44 |
| 210101 | Үндсэн цалин | - | 9,015,747,673.72 |
| 210102 | Нэмэгдэл | - | 664,221,558.35 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 73,487,487.79 |
| 210104 | Урамшуулал | - | 7,740,240,042.03 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 2,797,068,034.55 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | - | 1,045,257,557.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 99,741,893.54 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 11,287,309.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 5,516,286.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 4,096,559.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | - | 924,615,509.20 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | - | 418,159,910.70 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | 106,890,687.76 |
| 210302 | Түлш, халаалт | - | 153,407,401.44 |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | 10,193,184.00 |
| 210304 | Байрны түрээс | - | 147,668,637.50 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 2,001,731,693.63 |
| 210401 | Бичиг хэрэг | - | 134,152,924.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 837,740,386.70 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 116,859,787.93 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 5,125,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 800,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 907,053,595.00 |
| 2105 | Нормативт зардал | - | 2,571,321,515.01 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 38,559,729.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 1,012,840,047.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,519,921,739.01 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 13,760,422,386.40 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 12,769,838,011.40 |
| 210602 | Тавилга | - | 98,832,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 12,987,935.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 878,764,440.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 267,026,903.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 78,866,472.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 188,160,431.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 13,762,642,041.44 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 13,675,189,390.44 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 4,147,412.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 187,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 81,467,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 1,651,239.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,278,125,316.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 1,680,837,838.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 597,287,478.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 2,769,503,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 2,769,503,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 279,082,680.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 2,490,421,220.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 4,605,887,685.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 4,605,887,685.00 |
| 220001 | Барилга байгууламж | - | 4,381,209,085.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 224,678,600.00 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | - | 1,922,616,766.68 |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР/Олгосон санхүүжилт, шилжүүлэг/ | - | 1,922,616,766.68 |
| 6 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг/Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт/ | - | 1,922,616,766.68 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 65,693,460,472.17 |
| 350011 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 22,860,000.00 |
| 350013 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,571,817,452.00 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 11,044,515,825.44 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 52,054,267,194.73 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагдаагийн ерөнхий газар нь үндсэн үйл ажиллагааны зорилгоо "Хүний эрхийг дээдлэн шударга ёсыг эрхэмлэж, амар тайван нийгмийг бүрдүүлнэ", мөн "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын мэдээлэл, харилцаа холбоо, цахим технологи ашиглалтыг нэмэгдүүлж, үйл ажиллагааны мэргэшсэн байдлыг хангах, албан хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, менежментийн шинэлэг арга хэлбэрийг нэвтрүүлэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлнэ" гэж тодорхойлсон байна.

Тус газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний агентлаг юм.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цагдаагийн ерөнхий газрын даргын "Бүтэц орон тоо батлах тухай" 2025 оны мн-0б/268 тушаалаар байгууллагын бүтэц орон тоог баталж мөрдөж ажилласан байна.

Тайлант онд Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргатай байгуулсан "Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын хэлтэс ажиллуулах тухай" 14/25 дугаар гэрээний дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2025 оны А/163 дугаар тушаалаар Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын бүтцэд нийт 319 орон тоотой "Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газар /гэрээт/"-ыг шинээр байгуулсан байна.

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус агентлагийн тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилт 81 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлснийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ төлөвлөлт зохион байгуулалтын хэлтэс 97.7 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Дотоод хяналт аюулгүй байдлын газрын хяналт шалгалтын хэлтэс 10 орон тоотой ажиллаж, 2025 онд төлөвлөгөөт 5, төлөвлөгөөт бус 12 сэдвээр дотоод аудит гүйцэтгэж, давхардсан тоогоор 22 алба, нэгжид, нийт 149 заалт бүхий зөвлөмж хүргүүлж биелэлт, үр дүнг тооцон ажиллаж байна.

Тайлант хугацаанд Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, журамд өөрчлөлт ороогүй ч, дараах хууль, тогтоомжийг мөрдөн ажиллаж байна.

- Цагдаагийн албаны тухай хууль
- Дотоодын цэргийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засгийн газрын тогтоол
- ХЗДХС-ын тушаал
- Төрийн болон албаны нууцын тухай хууль

Тус агентлагийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлж, агентлагийн үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж, даргын 2013 оны 422 дугаар тушаалаар баталгаажуулж, 2016 оны 344, 2025 оны А/287 дүгээр тушаалаар тус тус нэмэлт өөрчлөлт оруулж, мөрдөн ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 78,939.6 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 15,912.3 | 16,114.7 | 202.4 |
| Авлага | 1,251.3 | 8,344.9 | 7,093.6 |
| Урьдчилгаа | 21,527.8 | 12,057.2 | (9,470.6) |
| Бараа материал | 84,917.7 | 123,189.4 | 38,271.7 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 15,179.0 | 25,361.0 | 10,182.0 |
| Үндсэн хөрөнгө | 304,019.2 | 336,679.7 | 32,660.5 |
| **Нийт хөрөнгө** | **442,807.4** | **521,747.0** | **78,939.6** |
| Өр төлбөр | 12,769.7 | 17,545.2 | 4,775.5 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 430,037.7 | 504,201.8 | 74,164.1 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **442,807.4** | **521,747.0** | **78,939.6** |

*Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарснаас авлага 7,093.6 сая төгрөг, бараа материал 38,271.7 сая төгрөг, бусад эргэлтийн хөрөнгө 10,182.0 сая төгрөг, үндсэн хөрөнгө 32,660.5 сая төгрөг, өр төлбөр 4,775.5 сая төгрөгөөр нэмэгдэж, урьдчилгаа 9,470.6 сая төгрөгөөр буурсан байна.

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 16,114.7 сая төгрөг болж, 202.3 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Касст байгаа бэлэн мөнгө | 0.4 | | (0.4) |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 15,912.0 | 16,114.7 | 202.7 |
| Төгрөг | 6,884.6 | 5,934.0 | (950.6) |
| Төрийн сангийн харилцах | 6,883.0 | 5,934.0 | (949.0) |

| | | | |
|---|---|---|---|
| Арилжааны банк дахь харилцах | 1.7 | - | (1.7) |
| Гадаад валют | 9,027.3 | 10,180.3 | 1,153.0 |
| Төрийн сангийн харилцах | 9,027.3 | 10,180.3 | 1,153.0 |
| **Дүн** | **15,912.4** | **16,114.7** | **202.3** |

*Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Монгол Улсын Ерөнхий сайдын “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 2025 оны 05 дугаар албан даалгаврын хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллагын Ахмадын сангийн 2,246.5 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт татан төвлөрүүлснээс шалтгаалан харилцахын үлдэгдэл буурсан, Эрүүгийн цагдаагийн газрын хэргийн барьцааны валютын ханшийн 1,153.0 сая төгрөгийн зөрүүг олзоор бүртгэсэнтэй холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Захиргааны удирдлагын газар бууны гэрчилгээний тэмдэгтийн хураамжийг тооцоо нийлээгүй 37.9 сая төгрөгийн татварын тайланд зөрүүтэй асуудлыг шийдвэрлээгүй;
- Эрүүгийн цагдаагийн алба суутган болон газрын төлбөрийн 51.3 сая төгрөгийн дутуу төлөлттэй, цалин хөлсний 74.1 сая төгрөгийн илүү төлөлттэй татварын тайланд зөрүүтэй асуудлын шийдвэрлээгүй, 2011 онд алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор Налайх дүүргийн 5 дугаар хороонд байрлах "Зуслангийн зориулалттай" 20 айлын газар нь байгууллагын нэр дээр бүртгэлтэй боловч орлогот аваагүй, нэр бүхий албан хаагчдад шилжүүлэхээр хандсан боловч шийдвэрлэгдээгүй, тус газрын үүссэн татварын төлбөрийг өр төлбөр үүсгээгүй 2.7 сая төгрөг, мөн тэтгэвэрт гарсан алба хаагч нарт Говь ХХК-аас 3.6 сая төгрөгийн ноолууран цамц нөмрөг зэрэг гарын бэлэг худалдан авч үр ашиггүй зардалд зарцуулсан, мөн 19м2 талбайд Кофе шоп ажилладаг хэдий ч түрээслээгүй;
- Тээврийн цагдаагийн алба татварын тайлангаар цалин хөлс, газар, тээврийн хэрэгсэл, улсын тэмдэгтийн хураамж зэрэг нийт 315.8 сая төгрөгийн дутуу төлөлт, газрын төлбөрийн 0.2 сая төгрөгийн илүү төлөлтийг зөрүүтэй тайлагнасан;
- Санхүү ар талын албаны Хангамжийн хэлтэс барьцаа хөрөнгийн дансанд байршиж байгаа чанарын баталгааны 5 хувийн барьцааг чөлөөлөх 11 аж ахуй нэгж байгууллага чанарын баталгаа цуцлуулах албан хүсэлт ирүүлээгүй, 73.0 сая төгрөгийн өглөгт тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй, хуулийн хугацаа дууссан, мөн төсвөөс гадаад томилолтын зардлыг 11.6 сая төгрөгийг илүү зарцуулсан, бэлэг дурсгалын цом, цэцгийн баглаа, дэвтэр, бал, мандат зэрэгт 116.9 сая төгрөгийг худалдан авч, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан;
- Стратеги бодлого инновац, хөгжлийн алба татварын автомашины агаарын бохирдлын тусгаагүй, цалин хөлсний 11.0 сая төгрөг илүү төлөлттэй;
- Төмөр замын цагдаагийн газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй газраа өгч, орон сууцны подвалын давхарт 207.6 сая төгрөгийн 20 автомашины граш авч, данс бүртгэлд бүртгэсэн боловч хөрөнгө эзэмших гэрчилгээг аваагүй, тус асуудлыг шийдвэрлээгүй;
- Автобааз дотоод хяналт сул байгаагаас татварын тайлан дах өглөг, авлагын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй, тээврийн хэрэгслийн татварыг зөрүүтэй тайлагнасан асуудлыг шийдвэрлээгүй;
- Сүлд чуулга нь тайлант онд үйл ажиллагааны орлогыг 15.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 57.0 мянган төгрөгийн орлого олсноос үндсэн үйл ажиллагааны орлого нь төрийн өмчийн эд хөрөнгө болох урлагийн их танхимыг тоглолтын зориулалтаар 8 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан түрээслүүлснээс бүрдсэн, гэвч төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн тохиолдолд түрээсийн орлогын 40.0 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх байтал 22.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Дотоодын цэргийн 810 дугаар анги бараа үйлчилгээний худалдан авалтын Е баримтын зардлыг барааны нэр төрөл, тоо ширхгээр гаргуулаагүй, бөөн дүнгээр шивүүлж, анхан шатны баримтад хавсаргасан;
- Дотоодын цэргийн 816 дугаар анги Тэмцээн уралдаанд амжилт гаргасан албан хаагчдыг цалингийн зардлаас шагнаж урамшуулсан 7.0 сая төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлж, 1.099.0 мянган төгрөгийн гүйлгэн зарцуулсан 1.0 сая төгрөг;
- Нийслэлийн цагдаагийн удирдах газар Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлээгүй бичиг хэрэг, аж ахуйн материалын зардалд 36.9 сая төгрөгийг зарцуулж, алба хаагчдад 11.0 сая төгрөгийн хүнсний дэмжлэг, тусламж үзүүлсэн, хөтөлбөр, арга хэмжээний зардлын төсөвт хоол, цайны зардал баталж, зарцуулж байгаа нь үрэлгэн зарцуулсан 24.6 сая төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зарцуулаагүй, өөрсдийн үйл ажиллагаандаа зарцуулсан 7.2 сая төгрөг, салбар, дүүргийн Цагдаагийн газар, хэлтсүүдэд өгсөн шатахууныг зардалд тусгаж тайлагнасан 4.5 сая төгрөг, илүү цаг ажилласан албан хаагчид нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хөтлөөгүй, төсвийн захирагчаар тушаалаар нийт 22.6 сая төгрөгийн нэмэгдэл хөлс, шагнал олгосон;
- Баянгол дүүргийн Цагдаагийн газар сургалтын хөтөлбөр, хамрагдсан албан тушаалтны ирцийн бүртгэл, зохион байгуулсан сургалт сурталчилгаатай холбоотой зардлын зарцуулалтын үр дүнг үнэлээгүй 13.0 сая төгрөг, гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зарцуулаагүй, хэсгийн хорооны байцаагч нарт өгсөн шатахуун зарцуулалтад тавих хяналт сул, нотлох баримт хангалтгүй 23.2 сая төгрөг, Тайлант хоёр албан хаагчдад цалин илүү тооцож олгосон, тооцоо нийлсэн актгүй төсвийг зөв зохистой удирдаагүй авлага үүсгэсэн 1.8 сая төгрөг;

- Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар Авто тээврийн хэрэгслийн угаалгын үйлчилгээний төлбөрийн тооцооны үлдэгдлийг баталгаажуулаагүй, авто тээврийн хэрэгслийн угаах өдрийн хуваарийг батлуулаагүй, санхүүжилт тогтмол бус тул тогтвортой үр ашигтай хэрэгжээгүй 5.4 сая төгрөг, Тайлант онд төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллаагүй 38.1 сая төгрөг, оны шилдэг тэргүүний албан хаагчдыг шагнал урамшууллын зардлыг бөөн дүнгээр нэг албан хаагчийн данс уруу хийж шагнал авсан албан хаагчдад бэлнээр олгосон, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бэлтгэсэн өндөр үзүүлэлт бүхий суурин компьютерын хуваарилалтыг оновчтой хийгээгүй 11.6 сая төгрөг;
- Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зарцуулаагүй, зөөврийн компьютер, принтер худалдан авсан 5.9 сая төгрөг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлээгүй бичиг хэрэг 9,581.0 мянган төгрөгийг зарцуулсан;
- Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газар зардлын ангилал зөрчиж тавилга эд хогшил бэлтгэсэн 19.9 сая төгрөг, Тайлант онд эм бэлдмэлийн зардлын төсвийг хэтрүүлсэн зарцуулсан 2.0 сая төгрөг, шатахууны анхан шатны баримтын бүрдэл дутуу 5.0 сая төгрөг, төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллаагүй 61.5 сая төгрөг;
- Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар Сургалтын тайлангийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад зардлаар бүртгэж тайлагнасан 3.6 сая төгрөг, төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах албан даалгаврыг хэрэгжүүлж ажиллаагүй 13.5 сая төгрөг;
- Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар хорт зуршлаас татгалзах сургалтыг ЕБС, ИДС-ийн сурагч нарт зохион байгуулсан сургалт сурталчилгаатай холбоотой зардлын зарцуулалтын үр дүнг үнэлээгүй 16.8 сая төгрөг, Нэмэлт санхүүжилтийн дансаар "Өсвөрийн сэргийлэгч бүлгэм" нь нийт 100 хүүхдүүдэд хоол, хүнс гарын бэлэг, үзвэр үйлчилгээ үзүүлсэн бүртгэл нотлох баримт хангалтгүй 12.4 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын даргын тушаалуудаар үр дүнгийн урамшуулал цалинг давхардуулан олгосон 4.1 сая төгрөг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлээгүй бичиг хэрэг 15.1 сая төгрөг, аж ахуйн материалын зардалд 7.1 сая төгрөгийг зарцуулсан;
- Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлээгүй бичиг хэрэг, аж ахуйн материалын зардалд 3.5 сая төгрөгийг зарцуулж, алба хаагчдад 3.3 сая төгрөгийн хүнсний дэмжлэг, тусламж үзүүлсэн, батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж албан хаагчид нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас сургалтын 1.2 сая төгрөгийн зардал олгосон;
- Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс сургалтын хөтөлбөр, хамрагдсан албан тушаалтны ирцийн бүртгэл, зохион байгуулсан сургалт сурталчилгаатай холбоотой зардлын зарцуулалтын үр дүнг үнэлээгүй 1.5 сая төгрөг, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын хэрэгжүүлэхгүйгээр бичиг хэрэг 1.5 сая төгрөг, албан хаагчдад хүнсний материал 6.9 сая төгрөг;
- Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлээгүй бичиг хэрэг, хангамжийн материал зэргийг авсан 6.2 сая төгрөг;
- Архангай аймгийн Цагдаагийн газар ЦЕГ-ын даргын 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 1 дугаар мэдэгдлээр Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын өмнөх оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитын шалгалтын үр дүнг үндэслэн газрын даргад үндсэн цалингийн 100.0 хувиар, ахлах нягтлан бодогчид үндсэн цалингийн 50.0 хувиар, тайлант оны аймгийн Цагдаагийн газрын даргын А/36 дугаар тушаалаар нягтлан бодогч, аж ахуйн ажилтан, нярав нарт үндсэн цалингийн 50.0 хувиар тооцож, нийт 4.4 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг төрийн албан хаагчид үр дүнгийн урамшуулалтай давхардуулан цалин, урамшууллын зардлаас олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан;
- Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газар тайлант онд дотоод албан томилолтоор ажилласан 70 алба хаагчид албан томилолтоор 381 хоног ажилласан томилолтын мөнгийг тооцож олгохдоо 3.8 сая төгрөгийн хоолны хөнгөлөлтийг томилолтоор ажилласан хугацаанд давхардуулан олгосон;
- Булган аймгийн Цагдаагийн газар түлш, шатах тослох материалын анхан шатны баримт дутуу 3.4 сая төгрөг;
- Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар Монгол банкны Говь-Алтай салбараас хамгаалалтын үүрэг гүйцэтгүүлэх гэрээний дагуу ажлын төлбөрийг шилжүүлэхдээ нэхэмжилсэн дүнгээс 2.0 сая төгрөгийг аймгийн Цагдаагийн газрын дансанд дутуу төвлөрүүлж, тус дүнгээр Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төв рүү хамгаалалтын ажилтнуудын хувцасны үнийг шилжүүлж тооцоо үүсгэсэн;
- Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар Ахмадын сангаас 13.0 сая төгрөгийн хууль журамд нийцээгүй урамшуулал олгосон, анхан шатны баримтад түүнийг үйлдсэн ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дараагүй, Ёс зүйн дэд хорооны гишүүдэд 21.2 сая төгрөгийн цалин олгосон;
- Дундговь аймгийн Цагдаагийн газар хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг харгалзан байгууллагын удирдлагад улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 1.9 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон, албан хаагчдад хоолны мөнгийг цалингийн сангаас давхардуулан олгосон;

- Өмнөговь аймгийн Цагдаагийн газар албан томилолтоор ажилласан алба хаагчдад 2.1 сая төгрөгийн хоолны үнийн хөнгөлөлт давхардуулан олгосон, олон нийтийн цагдаагийн үйл ажиллагаанд зарцуулахаар баталсан төсвөөс тээвэр шатахууны зардлыг 5.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;
- Орхон аймгийн Цагдаагийн газар байгууллагын дарга, нягтлан бодогчид ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 3.8 сая төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас олгосон;
- Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар томилолтын нөхөн олговор олгосон албан хаагчдад 1.2 сая төгрөгийн хоолны хөнгөлөлт давхардуулан олгосон,  үндсэн чиг үүрэгт хамааралгүй сагсан бөмбөгийн тэмцээнд оролцуулахаар алба хаагчдыг томилж, томилолтын зардал 3.7 сая төгрөгийг төсвөөс олгосон;
- Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар санхүүгийн тайлангийн тодруулга бэлтгээгүй;
- Төв аймгийн Цагдаагийн газар Зуунмод Политехникийн коллежид спорт заалны түрээсэнд 2.0 сая төгрөгийн зардлыг хичээл үйлдвэрлэлийн дадлага данснаас төлсөн;
- Ховд аймгийн Цагдаагийн газар 2025 онд албан хаагчдад албан томилолтоор ажилласан хугацаанд давхардсан тоогоор нэр бүхий 51 албан хаагчдад 2.2 сая төгрөгийн хоолны хөнгөлөлт давхардуулан олгосон, 24 албан хаагчдад 1.0 сая төгрөгийн томилолтыг илүү тооцон олгосон;
- Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулан бүртгээгүй шууд зардлаар бүртгэсэн 285.3 сая төгрөг, ажил гүйлгээг давхардуулан бүртгэсэн 1.5 сая төгрөг, Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн 38.3 сая төгрөг.

### 3.5.2 Авлага

Авлагын дансны үлдэгдэл 8,344.8 сая төгрөг болж, өмнөх оноос 7,093.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 84.3 | 325.7 | 241.4 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 243.7 | 180.6 | (79.5) |
| Татаас, санхүүжилтийн авлага | 694.5 | 7,032.1 | 600.8 |
| Байгууллагаасаа авах авлага | 111.5 | 697.4 | (1,096.0) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 117.2 | 109.0 | 6.3 |
| **Дүн** | **1,251.20** | **8,344.9** | **(542.6)** |

*Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлага дансны үлдэгдэл өссөн нь оны эцэст олгоогүй үр дүнгийн урамшууллаас тооцсон 241.3 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт, 7 байгууллагын урсгал данснаас 712.3 сая төгрөг, 32 байгууллагын 967.2 сая төгрөгийн татаас санхүүжилтийн буюу нэмэлт санхүүжилтийн авлага, ахмадын сангийн 2,246.5 сая төгрөгийн авлага, гэрээт харуул хамгаалалтын 585.8 сая төгрөгийн нормын хувцасны авлага тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.

*Аудитын илрүүлэлт:*

- Захиргааны удирдлагын газар тайлант онд татаас санхүүжилтийн 280.6 сая төгрөгийн авлага үүссэн;
- Эрүүгийн цагдаагийн алба нь тус албаны үр дүнгийн урамшуулал олгох гүйлгээ хийгдээгүйгээс нийт 38.2 сая төгрөгийн авлага үүссэнээс нийгмийн даатгалын шимтгэл, татварын 12.7 сая төгрөгийн илүү төлөлт, татаас санхүүжилтийн 11.6 сая төгрөг авлага, мөн 4.5 сая төгрөгийн өр төлбөр нэмэгдсэн;
- Тээврийн цагдаагийн алба Тайлант онд санхүүжилтийн 790.9 сая төгрөгийн, 0.3 сая төгрөгийн бусад, 3.4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт, 18.7 сая төгрөгийн татварын илүү төлөлт, нийт 813.4 сая төгрөгийн авлага үүссэн;
- Санхүү, ар талын алба найдваргүй авлага болох эрсдэлтэй, олон жилийн насжилттай 1.6 сая төгрөгийн тусгай зориулалтын авлага, малчнаас авах 25.6 сая төгрөг, Бэхэн хур ХХК-аас авах 2.5 сая төгрөг, Эму Жи Эл Вариор ХХК-аас авах 6.8 сая төгрөг, Саунд мюзик студи ХХК-аас авах 0.5 сая төгрөгийн авлага, 0.2 сая төгрөгийн хувь хүнд өгөх өглөг, 0.6 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг, нийт 38.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;
- Төмөр замын Цагдаагийн газар тайлант онд төлбөртэй үйлчилгээний 175.4 сая төгрөгийн, татаас санхүүжилтийн 477.8 сая төгрөгийн, нийт 653.3 сая төгрөгийн авлага нэмэгдсэн;
- Автобааз тайлант онд татаас санхүүжилтийн 44.8 сая төгрөгийн авлага үүссэн;
- Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв Тайлант онд татаас санхүүжилтийн 353.8 сая төгрөгийн авлага, байгууллагад төлөх 2.6 сая төгрөг, хувь хүнд төлөх 0.5 сая төгрөг, сургалтын урьдчилж орсон орлого 26.4 сая төгрөг, нийт 29.7 сая төгрөгийн өр төлбөр тус тус үүссэн;
- Сүлд чуулга Тайлант онд ахмадын сангийн дансны үлдэгдэл 22.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос давж орсон 42.0 сая төгрөгийг сангийн яамнаас татан төвлөрүүлснээс болж санхүүгийн тайлангаар 64.7 сая төгрөгийн авлагыг нэмж бүртгэсэн;
- Хангалт үйлчилгээний төв тайлант онд ахмадын сангийн дансны үлдэгдэл 9.3 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос давж орсон 269.4 сая төгрөг, нийт 278.7 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд нэмж бүртгэсэн;
- Сүүж-Уул амралт сувилал тайлант онд ахмадын сангийн дансны үлдэгдэл 14.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос давж орсон 106.0 сая төгрөг, нийт 120.8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд нэмж бүртгэсэн;
- Дотоодын цэргийн 05 дугаар анги нь тайлант онд ахмадын сангийн дансны үлдэгдэл 4.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос давж орсон 450.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн 66.7 сая төгрөг, нийт 521.3 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд нэмж бүртгэсэн.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 12,057.2 сая төгрөг болж, өмнөх оноос 9,470.6 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Урьдчилж гарсан зардал | 8,185.5 | 6,211.2 | (1,974.3) |
| Урьдчилгаа тооцоо | 13,342.3 | 5,846.0 | (7,496.3) |
| Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 4,034.1 | 1,527.1 | (2,507.0) |
| Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 9,308.2 | 4,319.0 | (4,989.2) |
| **Дүн** | **21,527.8** | **12,057.2** | **(9,470.6)** |

*Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа дансны үлдэгдэл буурахад тайлант онд Санхүү ар талын албаны тэтгэвэр тэтгэмжийн 18 сарын урьдчилгааны 7,496.3 сая төгрөг, нууцын байгууллагын 3,322.3 сая төгрөг, он дамжин хэрэгжиж байгаа алба хаагчдын хувцас, хэрэгслийн гэрээний дагуу шилжүүлсэн 2,507.0 сая төгрөг, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 4,989.2 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материал дансны үлдэгдэл 123,189.4 сая төгрөг болж, өмнөх оноос 38,271.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| **Түүхийн эд материал** | **22,710.6** | 32,927.7 | **10,217.1** |
| Тусгай зориулалтын материал | 22,459.7 | 32,660.2 | 10,200.5 |
| Эм боох материал | 250.9 | 267.4 | 16.5 |

| | | | |
|---|---|---|---|
| Бэлэн бүтээгдэхүүн | 16,206.3 | 28,459.7 | 12,253.4 |
| **Хангамжийн материал** | **44,940.4** | **60,715.0** | **15,774.6** |
| Бичиг хэргийн материал | 1,170.2 | 2,402.6 | 1,232.4 |
| Аж ахуйн материал | 2,372.6 | 2,542.3 | 169.7 |
| Сэлбэг хэрэгсэл | 1,379.4 | 1,380.0 | 0.6 |
| Түлш, Шатах тослох материал | 1,669.5 | 2,914.0 | 1,244.5 |
| Барилгын засварын материал | 466.2 | 773.6 | 307.4 |
| Хүнсний материал | 968.4 | 1,868.9 | 900.5 |
| Бусад хангамжийн материал | 36,914.1 | 48,833.6 | 11,919.5 |
| Мал амьтад | 1,060.2 | 1,087.0 | 26.8 |
| **Дүн** | **84,917.5** | **123,189.4** | **38,271.9** |

*Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд худалдан авсан 132,514.7 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 33.4 сая төгрөг, шилжүүлэн авсан 65,746.5 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн авсан 113.3 сая төгрөг, бусад 6,009.8 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн, зарцуулсан 58,912.2 сая төгрөг, шилжүүлсэн 99,569.7 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 113.3 сая төгрөгийн бусад 7,550.9 сая төгрөгийн бараа материал хасагдсантай холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Захиргааны удирдлагын газар тайлант онд 204.7 сая төгрөгийн хоол, хүнсний материал худалдан авч, 173.5 сая төгрөгийн хоол, хүнсний материалыг зарцуулж, зөвлөл болон зочид, удирдлагын хоолны зардалд 31.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;
- Сүүж-Уул амралт сувилал Петростар ХХК-тай байгуулсан "Шатахуун, дизель түлш нийлүүлэх" гэрээний хугацаанд 2025 онд 80.8 сая төгрөгийг шилжүүлж, Бараа материалын тайлангийн үлдэгдлээр 41.5 сая төгрөгийн шатахууны нөөц үүсгэсэн байна. Тодруулбал: шатахууны картад 10.0 сая төгрөг, бэлэн толон 31.5 сая төгрөг;
- Дотоодын цэргийн 810 дугаар анги Тайлант хугацаанд бараа материалын зарцуулалтын тайланг гаргахдаа байгууллагын дарга, нягтлан бодогч, эд хариуцагч нар гарын үсэг зурж баталгаажуулаагүй, шаардах хуудсыг бүрэн хөтлөөгүй;
- Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар хөрөнгийн дансны ангиллыг буруу бүртгэсэн буюу үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан;
- Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар бараа материал актлах тушаал шийдвэрийн дагуу устгаагүй байж тайлан балансаас хасаж бүртгэсэн;
- Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газар урсгал засварын материал зарцуулалтын өртгийн тооцоолол хийх боломжгүй, нотлох баримтын бүрдэл хангалтгүй;
- Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар урсгал засварын материалын бодит өртгийн тооцоолол хийх боломжгүй, нотлох баримтын бүрдэл хангалтгүй;
- Багануур дүүргийн Цагдаагийн хэлтэс бараа материал дансанд хөдөлгөөн оруулаагүй, ашиглагдахгүй хөрөнгүүд 6.2 сая төгрөг;
- Налайх дүүргийн Цагдаагийн хэлтэс бараа материал дансанд хөдөлгөөн оруулаагүй, ашиглагдахгүй хөрөнгүүд1.8 сая төгрөг;
- Сүхбаатар аймгийн Цагдаагийн газар тээвэр шатахууны зардлын зарцуулаагүй үлдэгдлийг дээд шатны төсөвт төвлөрүүлэхгүйгээр шатахууны картад шилжүүлж үлдэгдлээр илэрхийлсэн нь ажил гүйлгээний анги, үйл явцтай холбоотой ангилал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй;
- Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын Цагдаагийн хэлтэс бараа материалыг ангилал зөрүүлсэн 14.1 сая төгрөг.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 25,361.0 сая төгрөг болж, өмнөх оноос 10,181.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 15,179.1 | 25,361.0 | 10,181.9 |
| **Дүн** | **15,179.1** | **25,361.0** | **10,181.9** |

*Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Цагдаагийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж байгаа Төв, Завхан, Ховд, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын тасгийн барилга, Өвөрхангай аймгийн Уянга сумын тасгийн барилга угсралтын ажлын тайлант оны санхүүжилт нэмэгдсэн байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 521,747.0 сая төгрөг болж, өмнөх оноос 78,939.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл*

*/сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Биет хөрөнгө** | **279,161.9** | **311,664.0** | **32,502.1** |
| Барилга, байгууламж, орон сууц | 189,745.0 | 191,162.3 | 1,417.3 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 68,354.1 | 97,406.5 | 29,052.4 |
| Машин тоног төхөөрөмж /компьютер/ | 79,667.3 | 92,848.8 | 13,181.5 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,551.4 | 11,021.0 | 469.6 |
| Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 5,825.5 | 5,850.0 | 24.5 |
| Бусад үндсэн хөрөнгө | 17,405.3 | 24,332.5 | 6,927.2 |
| **Биет бус хөрөнгө** | **24,857.3** | **25,015.8** | **158.5** |
| Программ хангамж | 3,917.8 | 4,780.0 | 862.2 |
| Бусад биет бус хөрөнгө | 22,308.7 | 22,142.3 | (166.4) |
| **Дүн** | **442,807.4** | **521,747.0** | **78,939.6** |

*Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд худалдан авсан хөрөнгө 15,032.6 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 563.3 сая төгрөг, шилжүүлэн авсан 51,908.4 сая төгрөг, бусад 17,547.7 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1,039.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 6.8 сая төгрөг, акталсан 5,857.3 сая төгрөг, шилжүүлсэн 8,860.3 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 3713.9 сая төгрөг, бусад 17,684.7 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 1,761.4 сая төгрөгөөр тус тус хасагдсанаас шалтгаалжээ.

*Аудитын илрүүлэлт:*

- Сүлд чуулга элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 3 ангиллын 105 нэр төрлийн 37.5 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй;
- Дотоодын цэргийн 816 дугаар анги автомашинуудад 8 ш аккумлятор, 33 ширхэг дугуй худалдан авч тухайн сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар нормыг тогтоогоогүй;
- Баянгол дүүргийн Цагдаагийн газар Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын хэрэгжүүлэхгүйгээр ширээ, сейф, сандал тавилга эд хогшил, хангамжийн материал зэргийг авсан;
- Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлээс тооллого хийсэн хөрөнгийн үлдэгдэл зөрүүтэй буюу эд хариуцагчтай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулаагүй, эм боох материал дансны тооцоог бодож баталгаажуулаагүй;
- Хан-Уул дүүргийн Цагдаагийн газар нь жилийн эцсийн тооллогоор эм боох материал дансанд тооцоо бодсон акт үйлдээгүй, агуулахын бүртгэлийг дутуу хөтөлсөн, нэр бүхий албан хаагчдын хөрөнгийн картыг тооллогын комисс баталгаажуулаагүй;
- Архангай аймгийн Цагдаагийн газар нь байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг Цагдаагийн газрын даргын 2024 оны А/41 дугаар тушаалаар 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан боловч эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогын дүнг тушаалын дагуу Удирдах зөвлөлд танилцуулаагүй, комиссын гишүүд гарын үсгээр тооллогын бүртгэлийг баталгаажуулаагүй;
- Дорнод аймгийн Цагдаагийн газар Дорнод аймгийн ИТХ-ын 2025 оны 04/05 дугаар тогтоолоор Орон нутгийн өмчийн газрын эзэмшлийн 2011 онд үйлдвэрлэгдсэн, “Ниссан теана” маркийн 01-31 УЕК улсын дугаартай тээврийн хэрэгслийг аймгийн Цагдаагийн газарт (Дотоодын цэрэг)-т шилжүүлэхээр батлагдсан хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.

### 3.5.7 Өр төлбөр

Өглөгийн дансны үлдэгдэл 17,545.2 сая төгрөг болж, өмнөх оноос 4,775.6 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл*

*/ сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 149.6 | 9.3 | (140.3) |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 20.9 | 50.2 | 29.3 |
| Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 1,497.1 | 1,944.0 | 446.9 |
| Байгууллагад төлөх өглөг | 118.8 | 962.3 | 843.5 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 116.3 | 710.3 | 594.0 |
| **Урьдчилж орсон орлого** | **10,866.9** | **13,869.0** | **3,002.1** |
| Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого | 10,414.0 | 13,707.0 | 3,293.0 |
| Бусад урьдчилж орсон орлого | 452.9 | 162.0 | (290.9) |
| **Дүн** | **12,769.6** | **17,545.2** | **4,775.6** |

*Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь эхний үлдэгдэл 12,769.7 сая төгрөгөөр, 594,080.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 589,305.4 сая төгрөгөөр буурч, 17,545.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Санхүү, ар талын албаны 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга, тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааны гүйцэтгэл, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн чанарын баталгааны 5 хувийн барьцааны дансанд байршуулсан 446.8 сая төгрөг, Монгол Улсын Ерөнхий сайдын “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 2025 оны 05 албан даалгаврын хүрээнд Сангийн яамнаас зарим зардлыг хязгаарлаж, нэмэлт санхүүжилтийн эрх нээгээгүйгээс цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагад өр нэмэгдэж, худалдан авах ажиллагаа тендер зарласан Тээврийн агдаагийн албаны 736.0 сая төгрөгөөр өр үүсэж, Завхан, Говь-Алтай, Хэнтий аймгийн тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн тэтгэмж, 30 сарын урамшууллыг татан төвлөрүүлснээс алба хаагчдад өгөх 594.0 сая төгрөгөөр өглөг нэмэгдэж, Цагдаа, дотоодын цэргийн гэрээт харуул хамгаалалтын гэрээт ажилтны хувцас хэрэгслийн олголт 290.9 сая төгрөгөөр буурсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Тээврийн цагдаагийн алба тайлант онд бараа үйлчилгээний зардлын 33.0 сая төгрөг, шуудан холбооны 30.6 сая төгрөг, албан томилолтын 2.3 сая төгрөг, байгууллагад төлөх 748.0 сая төгрөг, хувь хүнд өгөх 1.7 сая төгрөг, нийт 782.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэн;
- Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар төсвийг зөв зохистой удирдаагүй, жилийн төсөвтөө багтаан өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй.

### 3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 504,201.8 сая төгрөг болж, өмнөх оноос 74,164.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо*

*/ сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Засгийн газрын оруулсан капитал | 88,118.3 | 88,108.2 | (10.1) |
| Хуримтлагдсан үр дүн | 287,395.9 | 362,877.1 | 75,481.2 |
| Өмнөх үеийн үр дүн | 205,965.3 | 288,847.3 | 82,882.0 |
| Тайлант үеийн үр дүн | 81,430.6 | 74,029.8 | (7,400.8) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 54,523.4 | 53,216.5 | (1,306.9) |
| **Дүн** | **430,037.7** | **504,201.8** | **74,164.1** |

*Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл өссөн нь Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар 135.7 сая төгрөгийн, НХЖХОНАБХА-ны 2.3 сая төгрөгийн газрыг шинээр бүртгэж, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар 2.8 сая төгрөгөөр, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар 98.7 сая төгрөгөөр бүртгэлтэй газраа хасаж, нийтийн эзэмшил болгосноос буурсантай холбоотой байна.

ЦЕГ-ын харьяа байгууллагуудын данснаас хассан барилгуудын дахин үнэлгээний 1,300.0 сая төгрөг, Монгол тамга ТӨҮГ-ын өмчид гарсан өөрчлөлтийн 2.6 сая төгрөг, ДЦШ 52.7 сая төгрөг, Баянхонгор аймгийн Цагдаагийн газар 1.3 сая төгрөг, Говь-Сүмбэр аймгийн Цагдаагийн газрын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил 1.2 сая төгрөг, Хэнтий аймгийн Цагдаагийн газрын шүүхийн шийдвэрээр барагдуулсан өр төлбөрийн 55.9 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний 1,306.9 сая төгрөгийг данснаас тус тус хасаж, өмнөх үеийн үр дүнг бууруулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цагдаагийн ерөнхий газар 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээс 732,122.2 сая төгрөг, Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих 237.1 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 33,649.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 105,145.7 сая төгрөгөөр бууруулж, 660,145.7 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 35,062.3 сая төгрөг, тогтмол зардлыг 2,803.0 сая төгрөг, хангамж бараа материалыг 5,781.7 сая төгрөг норматив зардал 12,086.3 сая төгрөг, эд хогшлын зардал 9,221.1 сая төгрөг, томилолт, зочны зардал 1,760.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 11,033.3 сая төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардал 14,258.3 сая төгрөг, урсгал шилжүүлэг 13,642.7 сая төгрөгөөр бууруулж баталсан нь харьяа байгууллагуудын төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны төсвийг тодотголоор 44,543.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 зорилт, хөтөлбөрийн 81 арга хэмжээг санхүүжүүлэхээр 598,599.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 252.5 сая төгрөг, Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих, 16,750.1 сая төгрөгийг үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээр байна.

**Улсын төсвийн орлого бүрдүүлэлт**

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 2,370.0 сая төгрөгийн улсын орлогот төвлөрүүлэхээр баталснаас 1,428.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөснөөс 942.0 сая төгрөг буюу 39.0 хувиар тасарсан байна.

Иргэдийн бичиг баримтын мэдээллүүд И-Монголиа системд орсноор төрөөс авдаг лавлагаа, тодорхойлолтуудыг “E-Mongolia” системд бүртгүүлж, нэвтрэн орсон хүн бүрийн иргэний үнэмлэх, жолоочийн үнэмлэхийн мэдээлэл цахим хэлбэрээр байршсанаар иргэд жолооны үнэмлэх хэвлүүлэх хэрэгцээ шаардлага багасаж, орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 614,330.7 сая төгрөгийн төсөв баталснаас 598,596.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 16,750.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор, 252.5 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 598,596.9 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 20,124.7 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалаас 358.0 сая төгрөг, нийт 615,020.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 532,393.7 сая төгрөгийг зарцуулж, урсгал төсвөөс 13,190.2 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлснээс татаас санхүүжилтийн 3,818.3 сая төгрөгийн авлагыг буцааж авахаар тооцоо нийлж, баталгаажуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 587,842.3 сая төгрөг буюу 88.7 хувьтай зарцуулсан байна.

*Аудитын илрүүлэлт:*
- Санхүү, ар талын алба Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны 01/533 дугаар албан бичгээр ХЗДХЯ-д Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2025 оны төсвийн төслийг хүргүүлснээс урсгал зардалд буюу “Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж”-ийн зардалд түрээсийн гэрээгээр үндсэн хөрөнгийг бэлтгэхээр төлөвлөсөн байна. Тодруулбал: Хөнгөн хуягт, туулах чадвар сайтай, моторын хүчин чадал 3500 CC, 3956 CC V6 байх шаардлагатай, өндөр өртөгтэй тээврийн хэрэгслийг урсгал төсвөөс түрээсийн гэрээгээр худалдан авах буюу төсвийг үрэлгэн байдлаар зарцуулахаар төлөвлөж хүргүүлснийг баталж, зарцуулсан;
- Өмнөговь аймгийн Цагдаагийн газар "Эрдэнэс монгол" ХХК-тай байгуулсан гэрээт цагдаагийн нэгж ажиллуулах тухай гэрээний дагуу олгосон санхүүжилтийг түүвэрлэн шалгахад цэвэр бохир усыг 1.1 сая төгрөг, бичиг хэргийн зардлыг 7.8 сая төгрөг, багаж техник хэрэгслийг 12.5 сая төгрөг, албан томилолтыг 24.3 сая төгрөг, эм боох 0.2 сая төгрөг, тавилга 3.0 сая төгрөгөөр баталсан төсвөөс хэтрүүлэн үйл ажиллагааны зардалд зарцуулсан.

*Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/сая төгрөгөөр/*

| Д/Д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Нийт дүн** | | **598,599.7** | **587,842.3** | **10,757.4** | **88.7** |
| **70704** | **Цагдаа** | **587,493.5** | **577,263.8** | **10,229.8** | **82.1** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 481,743.0 | 473,027.5 | 8,715.5 | 98.2 |
| 80103 | Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 5,126.9 | 5,126.8 | 0.1 | 100.0 |
| 80215 | Эрдэм шинжилгээ, судалгааны зардал | 44,090.0 | 44,034.1 | 55.9 | 99.9 |
| 80220 | Холбооны суваг ашигласны хөлс | 50.1 | 50.1 | - | 100.0 |
| 80509 | Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж | 147.4 | 147.4 | - | 100.0 |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 51,091.0 | 50,252.8 | 838.3 | 98.4 |
| 81569 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх | 656.5 | 464.7 | 191.8 | 70.8 |
| 81822 | Гадаад суралцагсдын зардал | 2,511.8 | 2,489.4 | 22.5 | 99.1 |
| 82201 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх | 27.0 | 14.0 | 13.0 | 51.9 |
| 82314 | Хугацаат цэргийн цолны цалин | 1,283.2 | 1,174.9 | 108.3 | 91.6 |
| 82315 | Байцаан шийтгэх ажиллагаа | 663.4 | 379.1 | 284.3 | 57.1 |
| 82324 | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа | 103.1 | 103.1 | - | 100.0 |
| **70711** | **Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах** | **11,106.2** | **10,578.6** | **527.7** | **95.2** |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 11,106.2 | 10,578.6 | 527.7 | 95.25 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Судалгааны үр дүн:**

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгааг авч, дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:
- Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолын 8.4, Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.5, Дотоодын цэргийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 9.2, дэх заалтыг үндэслэн албан хаагчдын хоолны хөнгөлөлтийг 10.0-20.0 мянган төгрөгөөр тогтоож, харьяа аудитад түүврээр хамрагддаг 21 байгууллагын нэгтгэлээр 5,153.4 сая төгрөгийн батлагдсан төлөвлөгөөнөөс, гүйцэтгэлээр 4,997.6 сая төгрөгийг зарцуулж, 155.7 сая төгрөгийг хэмнэсэн;

- Гадаад томилолтын арга хэмжээнд 112.3 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 222.5 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнд:
  - а. НИТХ-ын 2025 оны А/18 дугаар захирамжаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан зардлыг шийдвэрлүүлж, ЦЕГ-ын даргын 2025 оны Б/376 тушаалаар интерполын шугамаар эрэн сурвалжлагдах зардалд 62.4 сая төгрөг,
  - б. ЦЕГ-ын даргын “Гадаад улсад хуралд оролцуулах тухай” 2025 оны Б/1438 тушаал, НИТХ-ын даргын “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А/192 дугаар захирамжаар мансууруулах бодистой тэмцэх олон улсын 39 дүгээр их хурлын зардалд 15.0 сая төгрөг;
  - в. Үндэстэн дамнасан гэмт хэрэгт олон улсын интерпол, иргэдийг шилжүүлэн авах зардалд тус тус зарцуулсан байна.
- Төрд учирсан хохирол учруулсан асуудал байхгүй, түүнтэй холбоотой авлага үүсээгүй;
- ЦЕГ-ын хэмжээнд 105 нэр төрлийн 2,529.6 сая төгрөгийн лиценз, программ хангамж баланст бүртгэлтэй ашиглагдаж байна.
- ЦЕГ-ын харьяа аудитад түүврээр хамрагдах 21 байгууллагын сургалтын зардалд 4,054.7 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 3,854.7 сая төгрөгийг зарцуулсан; Тухайлбал:
  - - Энхийг дэмжих үйл ажиллагааны зардалд 3,208.8 сая төгрөг,
  - - ЦЕГ-ын даргын “Албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай” 2025 оны А/70 тушаалаар 180.0 сая төгрөг,
  - - Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын мэдлэг ур чадварын түвшин дээшлүүлэх сургалтын зардал болон аяны хүрээн зарцуулсан зардлууд;
- Тайлант онд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын баталсан орон тооноос нийт 770 орон тоог хасаж батлан 158,903.9 сая төгрөгийг төлөвлөснөөс, 41.2 сая төгрөгийг тодотголоор хасаж, гүйцэтгэлээр 118,232.5 сая төгрөгийг зарцуулсан;
- Урьдчилан сэргийлэх алба нь хэвлэл мэдээллийн 5 харилцагч байгууллагатай НИТХ-ын А/164 дүгээр захирамжийн дагуу НГХУСАЗ-ийн зардлын гэрээг байгуулж, урьдчилгаа 60.0 сая төгрөгийг шилжүүлж, гэрээний үлдэгдэл төлбөр 12.0 сая төгрөгийг шилжүүлээгүй байна.

### 3.5.3 *Нэмэлт төсөв*

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн болон орон нутгийн этгээдээс авсан хандив, тусламжаар 22.8 сая төгрөг, Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,571.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 11,044.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 52,054.2 сая төгрөг, нийт 65,693.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Цалин урамшуулал зардалд 20,290.8 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 1,045.2 сая төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардалд 418.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 2,001.7 сая төгрөг, норматив зардалд 2,571.3 сая төгрөг, эд хогшлын зардалд 13,760.4 сая төгрөг, томилолт зочны зардалд 267.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж 13,762.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 2,278.1 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 2,769.5 сая төгрөг, нийт 63,770.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,922.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснээс 967.2 сая төгрөгийг буцаан авахаар баталгаажуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4* **Тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах” 2025 оны А/08 дугаар тушаалаар харьяа 10 байгууллагад 79,562.9 сая төгрөгийн 37 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Мөн 2025 оны А/105 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны

төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, 19 байгууллагад 100,919.9 сая төгрөгийн 87 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Тодруулбал:

*Хүснэгт 11. Худалдан авах ажиллагаа төлөвлөгөө*

*/сая төгрөгөөр/*

| д/д | Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал | Харьяа байгууллагын тоо | Төсөл, арга хэмжээний тоо | Нийт төсөвт өртөг |
|---|---|---|---|---|
| 1 | 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/08 дугаар тушаал | 10 | 37 | 79,562.9 |
| 2 | 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/105 дугаар тушаал | 19 | 87 | 100,919.9 |

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний өөрчлөлтөөр 5 байгууллагад 31 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 16,568.7 сая төгрөгийн эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас шилжиж ирснийг нэмж баталсан учир өмнөх төлөвлөгөөнөөс 21,357.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант оны гүйцэтгэлээр 14 байгууллагын 91,644.8 сая төгрөгийн 82 төсөл арга хэмжээнд холбогдох эрх зүйн актын хүрээнд үнэлгээний хороог байгуулан tender.gov.mn цахим системд нээлттэй зарлаж, хуулийн дагуу шалгаруулалтыг зохион байгуулсан байна. Тендер шалгаруулалт амжилтгүй болсон 3 төсөл, арга хэмжээний 129.6 сая төгрөг, тендерийн хэмнэлтээс бий болсон 9,145.5 сая төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газарт Монгол Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар 7 төсөл, арга хэмжээнд 55,211.9 сая төгрөгийг, тайлант онд 39,753.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнийг төсөл арга хэмжээ тус бүрээр нь хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт 12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл*

*/сая төгрөгөөр/*

| д/д | Төсөл, арга хэмжээний нэр | | 2025 онд санхүүжих дүн | Гүйцэтгэл | Барьцаа | Төвлөрүүлсэн дүн |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Барилга байгууламж | Шилжих | 8,468.2 | 8,119.8 | | 348.4 |
| 2 | Их засвар | Шинэ | 1,671.5 | 1,671.4 | 83.6 | 18.7 |
| 3 | Тоног төхөөрөмж | Шинэ | 29,613.6 | 24,554.8 | 1178.2 | 5,058.8 |
| **Нийт дүн** | | | **39,771.9** | **34,346.0** | **1,261.8** | **5,425.9** |

Дээрх хүснэгтээс харахад хамгийн өндөр дүнгээр төсөв төвлөрүүлсэн тоног төхөөрөмж төсөл, арга хэмжээний тендерт шалгарсан мн-01а/2025-35 дугаар гэрээний Мершип ХХК техникийн тодорхойлолтыг хангаагүй, гэрээний хугацаанд нийлүүлээгүй учраас гэрээг цуцалж, 4,926.1 сая төгрөг, мн-1а/2025-26 дугаарт гэрээний Ивээлт гүн ХХК гэрээний хугацаанд тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй хугацаа хэтэрсэн хоногт алданги тооцож 6.6 сая төгрөг, тендерийн хэмнэлт 126.1 сая төгрөг, нийт 5,058.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Нийслэлийн Цагдаагийн удирдах газар ижил төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авалт хийхдээ тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж, шууд гэрээ байгуулсан, төсвийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй;
- Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар урсгал засварын ажлын хийх ажлын төсөв, харьцуулсан үнийн судалгаа, тухайн байгууллагыг сонгосон тэмдэглэл, гэрээ, ажлын явц гүйцэтгэлийг дүгнээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад зардлаар хүлээн зөвшөөрсөн;
- Говь-Алтай аймгийн Цагдаагийн газар худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүйгээр 26.7 сая төгрөгийн бичиг хэргийн материал, урсгал засварын зардлаас 27.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан.

### 3.5.5 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 2 хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 12 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ. Үүнээс:

- Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн нь зорилтот түвшиндээ хүрээгүй байцаан шийтгэх ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээнд 2025 оны 663.4 сая төгрөг баталснаас гүйцэтгэлээр 379.1 сая төгрөг зарцуулж, 57.1 хувийн биелэлттэй байна.
- Тухай төсөв нь Монгол Улсын Ерөнхий сайдын “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 2025 оны 05 дугаар албан даалгавар гарснаас 2025 оны урсгал төсвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, арга хэмжээнд 27.0 сая төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 14.0 сая төгрөг зарцуулж 51.8 хувийн биелэлттэй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсвийн төлөвлөлт, зардал, газрын асуудал, татварын тайлангийн зөрүүтэй асуудлыг шийдвэрлэх, журмыг мөрдөж ажиллаагүй зэрэг  холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор С.Отгонхорлоо, аудитор С.Шийлэгмаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/222 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 539,639.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 5,396.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээг авч ажилласан байна. Тухайлбал:

- Цахилгаан дулаан, эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэж, ажлын бус цагаар хэмнэлтийн ялгаатай түвшинд цагийн горимоор ажилладаг тоолуур тавьснаар тогтмол зардлыг 778.2 сая төгрөгөөр хэмнэсэн;
- Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг хот суурин газарт танхимаар зохион байгуулахгүй, цахим хэлбэрт оруулснаар  сургалтын танхимын түрээс 668.5 сая, шатахуун 412.1 сая, албан томилолтын зардлыг 564.3 сая төгрөгөөр хэмнэсэн.
- Бичиг хэргийн зардлыг хэмнэж, цахим архив, бичиг хэргийн нэгдсэн программ /earchive.police.gov/-ыг ашигласнаар бичиг хэргийн зардлыг тодорхой түвшинд хэмнэсэн

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох

журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

**Илрүүлэлт 1.** Цагдаагийн ерөнхий газрын Дотоод, хяналт, аюулгүй байдлын газар харьяа байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж, 9303 мэдээлэл байршуулахаас 9122 мэдээллийг байршуулж, 134 мэдээллийг хугацаа хоцроосон, хэрэгжилт 98.8 хувьтай гэж дүгнэсэн байна. Байгууллагын санхүүд тавих дотоод хяналт сул байгаагаас 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, бусад хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой 3,789.9 сая төгрөгийн 21 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1,886.0 сая төгрөгийн 7 албан шаардлага, 1,903.9 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй, хууль тогтоомжийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

**Илрүүлэлт 1.** Дотоод хяналт сул байгаагаас Татварын тайлантай холбоотой өглөг, авлагын үлдэгдлийг санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй, цалин хөлс, тээврийн хэрэгслийн татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөрийн зөрүүтэй асуудлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Татварын тайлангийн цалин хөлс, тээврийн хэрэгслийн татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөрийн зөрүүтэй асуудлуудыг шийдвэрлэж, тооцоо нийлж, тайланг баталгаажуулах зөвлөмж өглөө.

**Илрүүлэлт 2.** Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 дугаар тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах тайлагнах журам"-ын заалтыг мөрдөөгүй, НИТХ-ийн даргын "Эрх шилжүүлэх тухай" 2025 оны А/273 дугаар захирамжаар 83 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 1,300.0 сая төгрөгийг зарцуулах шийдвэр гарсан байна.

Энэ нь Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 дугаарт тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах тайлагнах журам", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай,

хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**<u>Өгсөн зөвлөмж:</u>** Холбогдох журмыг баримталж ажиллах, зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 5/131 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн өмнөх оны аудитаар алдаа, зөрчлийг арилгах 158.0 сая төгрөгийн 2 албан шаардлагыг бүрэн биелүүлж, 113.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг 70.0 хувьтай биелүүлж, нийт 85.00 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 13. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

| д.д | Үзүүлэлт | Өмнөх аудитаар | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| 1 | Албан шаардлага | 2 | 157,997.0 | 2 | 157,997.0 | 100.0 |
| 2 | Зөвлөмж | 9 | 113,397.0 | 7 | 113,397.0 | 70.0 |
| **Нийт дүн** | | **11** | **271,394.0** | **9** | **271,394.0** | **85.0** |

Харьяа байгууллагуудын тайлант оны санхүүгийн болон нийцлийн зөрчлийн нэгтгэлийн асуудлууд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Энхийг сахиулах үйл ажиллагаатай холбоотой гарсан зардлуудыг анхаарах авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой нийт 9,302.3 сая төгрөгийн 48 алдаа[1] илэрснээс аудитын явцад алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Тайлант оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд түүврээр хамрагдсан 4 харьяа байгууллагын үндсэн хөрөнгийн элэгдэл буруу тооцоолсноос 67.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1,943.0 сая төгрөгийн 107 зөрчил[2] илэрснээс, 75.0 сая төгрөгийн төлбөрийн 3 төлбөрийн акт тогтоож, 297.6 сая төгрөгийн 16 албан шаардлага хүргүүлж, 1,570.3 сая төгрөгийн 88 зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,939.7 сая төгрөгийн 103 зөрчил илэрсэнд 75.0 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 295.6 сая төгрөгийн 15 албан шаардлага хүргүүлж, 1,568.9 сая төгрөгийн 85 зөвлөмж өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 60 анги, байгууллагыг нэгтгэснээс холбогдох хуулийн дагуу 1 тайлан гүйцэтгэх ажиллагааны аудит хамрагдаж, 26 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 33 байгууллагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 3,345.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 67.6 сая төгрөгийн алдааг залруулж, цаашид давтан гаргахгүй байх, таслан зогсоох 1,964.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 1,312.7 сая төгрөгийг зөрчлийг арилгах 5 зөвлөмж өглөө.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс даваагүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

**<u>Илрүүлэлт 1.</u>** Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитаар илэрсэн зөрчил өмнөх оноос 959.5 сая төгрөгөөр буурсан боловч дотоод хяналтгүйгээс тайлант онд 1,939.7 сая төгрөгийн 103 зөрчил илрүүлснээс 75.0 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоох, 295.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 15 албан шаардлага, 1,568.9 сая төгрөгийн зөрчилд 85 зөвлөмж хүргүүлсэн. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 9,302.3 сая төгрөгийн 48 алдааг залруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т “дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Цагдаагийн ерөнхий газрын дотоод хяналт, сахилга хариуцлагыг сайжруулж, алдаа, зөрчлийг 20 хувиар бууруулах арга хэмжээг авч, үр дүнг тооцож ажиллах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Авлага, өглөг нэмэгдүүлсэнтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт 1.** ЦЕГ-ын авлага өмнөх оноос 7,093.6 сая төгрөгөөр нэмэгдсэн, тайлант онд 8,344.9 сая төгрөгийн авлага үүссэнээс татвар, НДШ-ийн илүү төлөлт 241.3 сая төгрөг, урсгал санхүүжилтээс 712.3 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 967.2 сая төгрөг, ахмадын сангийн 53 байгууллагын 2,246.5 сая төгрөг, хамгаалалтын гэрээний дагуу гэрээт харуул хамгаалалтын нормын хувцас 585.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 32 байгууллагын 3,106.0 сая төгрөг,  татаас санхүүжилтийн авлага нийт 7,032.0 сая төгрөгөөр авлага тус тус нэмэгдсэн, мөн өр, төлбөр өмнөх оноос 4,775.4 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 17,352.0 сая төгрөг болж, байгууллагад төлөх өглөг 594.0 сая төгрөгөөр, тэтгэмж урамшууллын санхүүжилтийг буцаан татан төвлөрүүлснээс 594.0 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж*: Авлага, өглөг нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авч ажиллах.

1. Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт 2.** Бүс нутгийн аюулгүй байдал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай тэмцэх сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, баяр ёслол арга хэмжээг зохион байгуулахад Санхүү ар талын алба 85.3 сая төгрөг, Тээврийн цагдаагийн алба удирдах зөвлөлийн цайны зардалд 6.2 сая төгрөг, Эрүүгийн цагдаагийн алба гарын бэлэг, хүлээн авалтын зардалд 39.4 сая төгрөг, Мөрдөн байцаах алба хүлээн авалт, засвар тохижилтын ажилд 35.4 сая төгрөг, нийт 166.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, төсвийг хэмнэлттэй зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Алдааны товч утга **/байгууллагын нэр/** | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Захиргааны удирдлагын газар | - | - | | | | | | | | | | |
| 2 | Эрүүгийн цагдаагийн алба | - | - | | | | | | | | | | |
| 3 | Мөрдөн шалгах алба | - | - | | | | | | | | | | |
| 4 | НХЖХОНАБХА | - | - | | | | | | | | | | |
| 5 | Тээврийн цагдаагийн алба | - | - | | | | | | | | | | |
| 6 | Гэмт хэрэг, Зөрчил шалгах алба | 1 | 22,209.9 | | | 1 | 22,209.9 | 1 | 22,209.9 | | | | |
| 7 | Санхүү, ар талын алба | 1 | 2,943,267.6 | | | 1 | 2,943,267.6 | 1 | 2,943,267.6 | | | | |
| 8 | Стратеги бодлого инновац, хөгжлийн алба | - | - | | | | | | | | | | |
| 9 | Экологийн цагдаагийн алба | 2 | 20,243.8 | 1 | 13,850.0 | 1 | 6,393.8 | 2 | 20,243.8 | | | | |
| 10 | Урьдчилан сэргийлэх алба | | | | | | | | | | | | |
| 11 | Төмөр замын цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 12 | Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газар | 1 | 19,153.8 | | | 1 | 19,153.8 | 1 | 19,153.8 | | | | |
| 13 | ЦЕГ-ын Автобааз | - | - | | | | | | | | | | |
| 14 | Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв | - | - | | | | | | | | | | |
| 15 | Сүлд чуулга | 1 | 6,042.6 | | | 1 | 6,042.6 | 1 | 6,042.6 | | | | |
| 16 | Хүч спорт хороо | - | - | | | | | | | | | | |
| 17 | Хангалт үйлчилгээний төв | - | - | | | | | | | | | | |
| 18 | Сүүж-Уул амралт, сувилал | - | - | | | | | | | | | | |
| 19 | Гэрээт | - | - | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | Дотоодын цэргийн штаб | - | - | | | | | | | | | | |
| 21 | ДЦ-ийн 05 дугаар анги | - | - | | | | | | | | | | |
| 22 | ДЦ-ийн 805 дугаар анги | - | - | | | | | | | | | | |
| 23 | ДЦ-ийн 809 дүгээр анги | | | | | | | | | | | | |
| 24 | ДЦ-ийн 810 дугаар анги | - | - | | | | | | | | | | |
| 25 | ДЦ-ийн 816 дугаар анги | 5 | 4,293,405.9 | 1 | 4,160,451.6 | 4 | 132,954.3 | 5 | 4,293,405.9 | | | | |
| 26 | Нийслэлийн цагдаагийн удирдах газар | 7 | 167,781.8 | | | 7 | 167,781.8 | 7 | 167,781.8 | | | | |
| 27 | Баянгол дүүргийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 28 | Баянзүрх дүүргийн цагдаагийн газар | 1 | 32,866.5 | | | 1 | 32,866.5 | 1 | 32,866.5 | | | | |
| 29 | Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 30 | Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар | 1 | 34,404.3 | | | 1 | 34,404.3 | 1 | 34,404.3 | | | | |
| 31 | Хан-Уул дүүргийн цагдаагийн газар | 1 | 10,273.3 | | | 1 | 10,273.3 | 1 | 10,273.3 | | | | |
| 32 | Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 33 | Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс | 2 | 393,187.2 | | | 2 | 393,187.2 | 2 | 393,187.2 | | | | |
| 34 | Багахангай дүүргийн цагдаагийн хэлтэс | - | - | | | | | | | | | | |
| 35 | Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс | 1 | 6,390.0 | | | 1 | 6,390.0 | 1 | 6,390.0 | | | | |
| 36 | Архангай аймгийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 37 | Баян-Өлгий аймгийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 38 | Баянхонгор аймгийн цагдаагийн газар | 6 | 259,408.4 | 3 | 6,389.8 | 3 | 253,018.7 | 6 | 259,408.4 | | | | |
| 39 | Булган аймгийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 40 | Говь-Алтай аймгийн цагдаагийн газар | 1 | 11,700.0 | | | 1 | 11,700.0 | 1 | 11,700.0 | | | | |
| 41 | Говьсүмбэр аймгийн цагдаагийн газар | 3 | 8,818.1 | 1 | 52.9 | 2 | 8,765.2 | 3 | 8,818.1 | | | | |
| 42 | Дархан-Уул аймгийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 43 | Дорнод аймгийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 44 | Дорноговь аймгийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 45 | Дорноговь аймгийн Замын-Үүд сумын цагдаагийн хэлтэс | - | - | | | | | | | | | | |
| 46 | Дундговь аймгийн цагдаагийн газар | 1 | 540.0 | 1 | 540.0 | | | 1 | 540.0 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 47 | Завхан аймгийн цагдаагийн газар | 1 | 15,492.3 | 1 | 15,492.3 | | | 1 | 15,492.3 | | | | |
| 48 | Өвөрхангай аймгийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 49 | Өвөрхангай аймгийн Хархорин сумын цагдаагийн хэлтэс | - | - | | | | | | | | | | |
| 50 | Өмнөговь аймгийн цагдаагийн газар | 2 | 3,661.8 | | | 2 | 3,661.8 | 2 | 3,661.8 | | | | |
| 51 | Орхон аймгийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 52 | Сүхбаатар аймгийн цагдаагийн газар | 2 | 114,142.5 | | | 2 | 114,142.5 | 2 | 114,142.5 | | | | |
| 53 | Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар | 2 | 3,272.9 | 2 | 3,272.9 | | | 2 | 3,272.9 | | | | |
| 54 | Сэлэнгэ аймгийн Мандал сумын цагдаагийн хэлтэс | - | - | | | | | | | | | | |
| 55 | Сэлэнгэ аймгийн Сайхан сумын цагдаагийн хэлтэс | - | - | | | | | | | | | | |
| 56 | Төв аймгийн цагдаагийн газар | 1 | 7,443.7 | | | 1 | 7,443.7 | 1 | 7,443.7 | | | | |
| 57 | Увс аймгийн цагдаагийн газар | - | - | | | | | | | | | | |
| 58 | Ховд аймгийн цагдаагийн газар | 1 | 1,920.0 | 1 | 1,920.0 | | | 1 | 1,920.0 | | | | |
| 59 | Хөвсгөл аймгийн цагдаагийн газар | 2 | 34,809.9 | | | 2 | 34,809.9 | 2 | 34,809.9 | | | | |
| 60 | Хэнтий аймгийн цагдаагийн газар | 2 | 891,868.4 | 1 | 6,380.0 | 1 | 885,488.4 | 2 | 891,868.4 | | | | |
| 61 | Нэтгэсэн тайлан | - | - | | | | | | | | | | |
| **НИЙТ ДҮН** | | **48** | **9,302,304.7** | **12** | **4,208,349.5** | **36** | **5,093,955.3** | **48** | **9,302,304.7** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга **/байгууллагын нэр/** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Захиргааны удирдлагын газар | 3 | 31,141.8 | | | | | 3 | 31,141.8 | | | | |
| 2 | Эрүүгийн цагдаагийн алба | 5 | 6,395.8 | | | | | 5 | 6,395.8 | | | | |
| 3 | Мөрдөн байцаах алба | - | - | | | | | | | | | | |
| 4 | НХЖХОНАБХА | - | - | | | | | | | | | | |
| 5 | Тээврийн цагдаагийн алба | 4 | 46,146.6 | | | | | 4 | 46,146.6 | | | | |
| 6 | Гэмт хэрэг, зөрчил шалгах алба | | | | | | | | | | | | |
| 7 | Санхүү, ар талын алба | 4 | 239,714.3 | 1 | 73,008.8 | 1 | 38,077.5 | 2 | 128,628.0 | | | | |
| 8 | Стратеги бодлого инновац, хөгжлийн алба | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 9 | Экологийн цагдаагийн алба | - | - | | | | | | | | | | |
| 10 | Урьдчилан сэргийлэх алба | | | | | | | | | | | | |
| 11 | Төмөр замын цагдаагийн газар | 2 | 207,285.5 | | | | | 2 | 207,285.5 | | | | |
| 12 | Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газар | | | | | | | | | | | | |
| 13 | ЦЕГ-ын Автобааз | 2 | - | | | | | 2 | - | | | | |
| 14 | Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 15 | Сүлд чуулга | 3 | 60,347.9 | | | 1 | 37,547.9 | 2 | 22,800.0 | | | | |
| 16 | Хүч спорт хороо | - | - | | | | | | | | | | |
| 17 | Хангалт үйлчилгээний төв | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 18 | Сүүж-Уул амралт, сувилал | - | - | | | | | | - | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Дотоодын цэргийн 05 дугаар анги | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 20 | Гэрээт | - | - | | | | | | | | | | |
| **Дүн** | | **27** | **591,031.9** | **1** | **73,008.8** | **2** | **75,625.4** | **24** | **442,397.7** | | | | |
| 20 | Нийслэлийн цагдаагийн удирдах газар | 6 | 179,699.6 | | | 1 | 72,852.5 | 5 | 106,847.1 | | | | |
| 21 | Баянгол дүүргийн цагдаагийн газар | 4 | 91,833.6 | | | | | 4 | 91,833.6 | | | | |
| 22 | Баянзүрх дүүргийн цагдаагийн газар | 7 | 117,486.5 | | | | | 7 | 117,486.5 | | | | |
| 23 | Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар | 4 | 68,379.9 | | | | | 4 | 68,379.9 | | | | |
| 24 | Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар | 5 | 105,723.4 | | | 1 | 19,998.0 | 4 | 85,725.4 | | | | |
| 25 | Хан-Уул дүүргийн цагдаагийн газар | 4 | 93,776.2 | | | | | 4 | 93,776.2 | | | | |
| 26 | Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар | 5 | 57,342.2 | | | 1 | 4,170.0 | 4 | 53,172.2 | | | | |
| 27 | Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс | 3 | 14,266.4 | | | | | 3 | 14,266.4 | | | | |
| 28 | Багахангай дүүргийн цагдаагийн хэлтэс | 2 | 9,949.0 | | | | | 2 | 9,949.0 | | | | |
| 29 | Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс | 2 | 8,066.5 | | | | | 2 | 8,066.5 | | | | |
| **Дүн** | | **42** | **746,523.3** | **-** | **-** | **3** | **97,020.5** | **39** | **649,502.8** | **-** | **-** | **-** | **-** |
| 30 | Архангай аймгийн цагдаагийн газар | 2 | 4,497.0 | | | 2 | 4,497.0 | | | | | | |
| 31 | Баян-Өлгий аймгийн цагдаагийн газар | 1 | 3,810.0 | | | | | 1 | 3,810.0 | | | | |
| 32 | Баянхонгор аймгийн цагдаагийн газар | 1 | - | | | | | 1 | | | | | |
| 33 | Булган аймгийн цагдаагийн газар | 1 | 3,452.0 | | | | | 1 | 3,452.0 | | | | |
| 34 | Говь-Алтай аймгийн цагдаагийн газар | 2 | 56,653.9 | | | | | 2 | 56,653.9 | | | | |
| 35 | Говьсүмбэр аймгийн цагдаагийн газар | | - | | | | | | | | | | |
| 36 | Дархан-Уул аймгийн цагдаагийн газар | 4 | 43,479.1 | | | 1 | 13,068.0 | 3 | 30,411.1 | | | | |
| 37 | Дорнод аймгийн цагдаагийн газар | 2 | 29,445.9 | | | | | 2 | 29,445.9 | | | | |
| 38 | Дорноговь аймгийн цагдаагийн газар | | - | | | | | | | | | | |
| 39 | Дорноговь аймгийн Замын-Үүд сумын цагдаагийн хэлтэс | | - | | | | | | | | | | |
| 40 | Дундговь аймгийн цагдаагийн газар | 2 | 2,742.5 | 1 | 800.0 | 1 | 1,942.5 | | | | | | |
| 41 | Завхан аймгийн цагдаагийн газар | | - | | | | | | | | | | |
| 42 | Өвөрхангай аймгийн цагдаагийн газар | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | Өвөрхангай аймгийн Хархорин сумын цагдаагийн хэлтэс | | - | | | | | | | | | | |
| 44 | Өмнөговь аймгийн цагдаагийн газар | 3 | 56,695.4 | | | 3 | 56,695.4 | | | | | | |
| 45 | Орхон аймгийн цагдаагийн газар | 1 | 3,885.0 | | | | | 1 | 3,885.0 | | | | |
| 46 | Сүхбаатар аймгийн цагдаагийн газар | 3 | 41,960.0 | 1 | 1,280.0 | 1 | 37,000.0 | 1 | 3,680.0 | | | | |
| 47 | Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар | | - | | | | | | | | | | |
| 48 | Сэлэнгэ аймгийн Мандал сумын цагдаагийн хэлтэс | 1 | 14,105.0 | | | | | 1 | 14,105.0 | | | | |
| 49 | Сэлэнгэ аймгийн Сайхан сумын цагдаагийн хэлтэс | | - | | | | | | | | | | |
| 50 | Төв аймгийн цагдаагийн газар | 1 | 2,100.0 | | | | | 1 | 2,100.0 | | | | |
| 51 | Увс аймгийн цагдаагийн газар | | - | | | | | | | | | | |
| 52 | Ховд аймгийн цагдаагийн газар | 1 | 3,300.0 | | | | | 1 | 3,300.0 | | | | |
| 53 | Хөвсгөл аймгийн цагдаагийн газар | 3 | 325,153.9 | | | | | 3 | 325,153.9 | | | | |
| 54 | Хэнтий аймгийн цагдаагийн газар | 1 | 2,782.2 | | | 1 | 2,782.2 | | | | | | |
| **Дүн** | | **29** | **594,061.9** | **2** | **2,080.0** | **9** | **115,985.1** | **18** | **475,996.8** | **-** | **-** | **-** | **-** |
| 55 | Дотоодын цэргийн штаб | - | - | | | | | | | | | | |
| 56 | ДЦ-ийн 05 дугаар анги | - | - | | | | | | | | | | |
| 57 | ДЦ-ийн 805 дугаар анги | - | - | | | | | | | | | | |
| 58 | ДЦ-ийн 809 дүгээр анги | | | | | | | | | | | | |
| 59 | ДЦ-ийн 810 дугаар анги | 2 | - | | | | | 2 | - | | | | |
| 60 | ДЦ-ийн 816 дугаар анги | 3 | 8,126.7 | | | 1 | 7,027.7 | 2 | 1,099.0 | | | | |
| **Дүн** | | **5** | **8,126.7** | **-** | **-** | **1** | **7,027.7** | **4** | **1,099.0** | **-** | **-** | **-** | **-** |
| **Нийт дүн** | | **103** | **1,939,743.8** | **3** | **75,088.8** | **15** | **295,658.7** | **85** | **1,568,996.3** | **-** | **-** | | |
| 61 | Нэгтгэсэн тайлан | 4 | 3,277.4 | | | 1 | 1,964.7 | 3 | 1,312.7 | | | | |
| **Дүн** | | **4** | **3,277.4** | **-** | **-** | **1** | **1,964.7** | **3** | **1,312.7** | **-** | **-** | **-** | **-** |
| **Нийт дүн** | | **107** | **1,943,021.2** | **3** | **75,088.8** | **16** | **297,623.4** | **88** | **1,570,309.0** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Д.д | Зөрчлийн товч утга **/байгууллагын нэр/** | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | | |
| 1 | Захиргааны удирдлагын газар | - | - | | | | | | |
| 2 | Эрүүгийн цагдаагийн алба | - | - | | | | | | |
| 3 | Мөрдөн шалгах алба | 1 | 224,367.6 | | | | | 1 | 224,367.6 |
| 4 | НХЖХОНАБХА | - | - | | | | | | |
| 5 | Тээврийн цагдаагийн алба | 1 | 2,374.5 | | | | | 1 | 2,374.5 |
| 6 | Гэмт хэрэг, Зөрчил шалгах алба | - | - | | | | | | |
| 7 | Санхүү, ар талын алба | - | - | | | | | | |
| 8 | Стратеги бодлого инновац, хөгжлийн алба | 1 | 218,009.7 | | | | | 1 | 218,009.7 |
| 9 | Экологийн цагдаагийн алба | - | - | | | | | | |
| 10 | Урьдчилан сэргийлэх алба | - | - | | | | | | |
| 11 | Төмөр замын цагдаагийн газар | 1 | 1,240,775.7 | | | | | 1 | 1,240,775.7 |
| 12 | Нийслэлийн замын хөдөлгөөний хяналтын газар | - | - | | | | | | |
| 13 | ЦЕГ-ын Автобааз | - | - | | | | | | |
| 14 | Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв | 1 | 11,113.0 | | | | | 1 | 11,113.0 |
| 15 | Сүлд чуулга | - | - | | | | | | |
| 16 | Хүч спорт хороо | - | - | | | | | | |
| 17 | Хангалт үйлчилгээний төв | - | - | | | | | | |
| 18 | Сүүж-Уул амралт, сувилал | - | - | | | | | | |
| 19 | Гэрээт | - | - | | | | | | |
| 20 | Дотоодын цэргийн штаб | - | - | | | | | | |
| 21 | ДЦ-ийн 05 дугаар анги | 1 | 207,274.7 | | | | | 1 | 207,274.7 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | ДЦ-ийн 805 дугаар анги | - | - | | | | | | |
| 23 | ДЦ-ийн 809 дүгээр анги | - | - | | | | | | |
| 24 | ДЦ-ийн 810 дугаар анги | - | - | | | | | | |
| 25 | ДЦ-ийн 816 дугаар анги | - | - | | | | | | |
| 26 | Баянгол дүүргийн цагдаагийн газар | 1 | - | | | | | 1 | - |
| 27 | Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газар | 1 | - | | | | | 1 | - |
| 28 | Баянхонгор аймгийн цагдаагийн газар | 1 | 880,732.2 | | | 1 | 880,732.2 | | |
| 29 | Булган аймгийн цагдаагийн газар | 1 | - | | | | | 1 | - |
| 30 | Говьсүмбэр аймгийн цагдаагийн газар | 1 | - | | | 1 | - | | |
| 31 | Дархан-Уул аймгийн цагдаагийн газар | 1 | - | | | | | 1 | - |
| 32 | Өвөрхангай аймгийн цагдаагийн газар | 1 | - | | | | | 1 | - |
| 33 | Өвөрхангай аймгийн Хархорин сумын сум дундын цагдаагийн хэлтэс | 1 | - | | | | | 1 | - |
| 34 | Өмнөговь аймгийн цагдаагийн газар | - | - | | | | | | |
| 35 | Дорнод аймгийн цагдаагийн газар | 1 | - | | | | | 1 | |
| 36 | Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар | 1 | - | | | | | 1 | |
| 37 | Сэлэнгэ аймгийн Мандал сумын сум дундын цагдаагийн хэлтэс | - | - | | | | | | |
| 38 | Хэнтий аймгийн цагдаагийн газар | 1 | 885,522.6 | | | 1 | 885,522.6 | | |
| 39 | Нэгтгэсэн тайлан | 1 | - | | | 1 | - | | |
| Дүн | | 18 | 3,670,170.0 | - | - | 4 | 1,766,254.8 | 14 | 1,903,915.2 |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | | |
| 1 | Нийслэлийн цагдаагийн удирдах газар | 3 | 118,535.9 | | | 3 | 118,535.9 | | |
| 2 | Өмнөговь аймгийн цагдаагийн газар | 1 | 1,200.0 | | | 1 | 1,200.0 | | |
| 3 | Нэгтгэсэн тайлан | 2 | - | | | | | 2 | - |
| Дүн | | 6 | 119,735.9 | - | - | 4 | 119,735.9 | 2 | - |
| **Нийт дүн** | | **24** | **3,789,905.9** | **-** | **-** | **8** | **1,885,990.7** | **16** | **1,903,915.2** |

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр Дугаар 1164/А1560348 Улаанбаатар хот

САГ - 2026/18/ИА-СТА-ТТ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод, хяналт, аюулгүй байдлын газар тайлант онд харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, 9303 мэдээлэл байршуулахаас 9122 мэдээллийг байршуулж, 134 мэдээллийг хугацаа хоцроосон, хэрэгжилт 98.8 хувьтай гэж дүгнэсэн боловч байгууллагын санхүүд тавих дотоод хяналт сул байгаагаас 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль, бусад хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой 3,789,906,000.00 /Гурван тэрбум долоон зуун наян есөн сая есөн зуун зургаан мянган/ төгрөгийн 21 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1,885,991,000.00 /Нэг тэрбум найман зуун наян таван сая есөн зуун ерэн нэгэн мянган/ төгрөгийн 7 албан шаардлага, 1,903,915,000.00 /Нэг тэрбум есөн зуун гурван сая есөн зуун арван таван мянган/ төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Төсвийн тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-36.Docx

1526101605

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал (Ж.Болд), Ерөнхий нягтлан бодогч, ахлах хошууч (М.Ралдийжамц), Дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа В.Хосбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ДОЛГОРСҮРЭН

АХЛАХ АУДИТОР С.ОТГОНХОРЛОО

АУДИТОР С.ШИЙЛЭГМАА

9006109
АТА16087
9025081411

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 25 өдөр Дугаар 1165/А1560348 Улаанбаатар хот

САГ-2026/18/ИА-СТА-ТТ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийхэд аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын нэгжийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйгээс харьяа 60 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 9,302,304,700.00 /Есөн тэрбум гурван зуун хоёр сая гурван зуун дөрвөн мянга долоон зуун/ төгрөгийн 48 алдааг залруулж, 1,964,738,000.00 /Нэг тэрбум есөн зуун жаран дөрвөн сая долоон зуун гучин найман мянган/ төгрөгийн 103 зөрчил илрүүлснээс 75,088,800.00 /Далан таван сая наян найман мянга найман зуун/ төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 295,658,700.00 /Хоёр зуун ерэн таван сая зургаан зуун тавин найман мянга долоон зуун/ төгрөгийн зөрчилд 15 албан шаардлага хүргүүлж, 1,593,990,500.00 /Нэг тэрбум таван зуун ерэн гурван сая ерэн есөн мянга таван зуун/ төгрөгийн зөрчилд 85 зөвлөмж хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т "дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагаа", 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.6-д "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх", 14 дүгээр зүйлийн 14.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 15 дугаар зүйлийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасныг тус тус зөрчсөн байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-36.Docx*

1526191697

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтыг сайжруулж, илэрсэн алдаа, зөрчлийг 20-оос доошгүй хувиар бууруулах арга хэмжээг авч, зөрчлийг арилгаж, биелэлтийн тайлан, нотлох баримтыг 2026 оны 12 дугээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал (Ж.Болд), Ерөнхий нягтлан бодогч, ахлах хошууч (М.Ралдийжамц), Дотоод аудитын хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа В.Хосбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Б.ДОЛГОРСҮРЭН |
| АХЛАХ АУДИТОР | С.ОТГОНХОРЛОО |
| АУДИТОР | С.ШИЙЛЭГМАА |

9056109
АТА16087
9025081411